



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 05

Мөрөн сум

Орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн орон нутгийн эзэмшлийн хувьцааг хувьчлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2.3, 78 дугаар зүйлийн 78.2.6, 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XXIV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Үүрийн долгио” орон нутгийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг 100 хувь хувьчилсугай.
2. Орон нутгийн өмчийг хувьчлах арга хэлбэрийг хавсралтаар баталсугай.
3. Батлагдсан арга хэлбэрийг чиглэл болгон зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засаг дарга (П.Лхагважав)-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтийг 2024 оны 03 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнахыг аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д даалгасугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Төмөрхуяг)-т даалгасугай.

ДАРГА

Г.МӨНГӨНХУЯГ

6712000127

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12  
дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус XXIV  
хуралдааны 15 тогтоолын хавсралт

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ОРОН НУТГИЙН  
ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ХУВЬЧЛАХ АРГА ХЭЛБЭР**

**Нэг. Хувьчлалын үндсэн зарчим**

1.1. Орон нутгийн өмчийг хувьчлахад хууль эрх зүйн хүрээнд ил тод, нээлттэй хэрэгжүүлэх.

**Хоёр. Хувьчлалын ажлыг зохион байгуулах арга хэлбэр**

2.1. Хувьчлах ажлыг дараах зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ:

2.1.1 “Үүрийн долгио” Орон нутгийн өмчит хязгаарлагдмал компанийн (цаашид ОНӨХК гэх) орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг үндсэн ажил үйлчилгээний зориулалтыг өөрчлөхгүйгээр 100 хувь хувьчлах,

2.1.2 “Үүрийн долгио” ОНӨХК-ийн орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй ажиллуулах тухайн компанийн хувьцаа эзэмшигчдэд санал болгох;

2.1.3. Энэ арга хэлбэрийн 2.1.2-д заасан компанийн хувьцаа эзэмшигчид түдгэлзсэн тохиолдолд “Үүрийн долгио” ОНӨХК-ийн орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүй үргэлжлүүлэн ажиллуулах иргэн, хуулийн этгээдэд нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах;

2.1.4 Хувьцааг худалдан авсан этгээдэд хувьцааг шилжүүлэх шийдвэрийг гаргах, хүргүүлэх;

2.1.5 Хувьчлалаас орсон орлогыг аймгийн Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлэх;

**Гурав. Хувьчлах, өөрчлөн байгуулах орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд**

3.1 “Үүрийн долгио” ОНӨХК-ийн орон нутгийн өмчид ногдох 27 хувийн хувьцааг хувьчилж, худалдан авсан этгээдтэй байгуулах гэрээнд эрэлт хэрэгцээнд нийцүүлэн стандартын шаардлагыг хангасан үйлчилгээг тогтвортой явуулахыг чиглэл болгох.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_